

ХАР БАЛГАСААС ИЛЭРСЭН ХҮРЭЛ ЯЛТАС ДЭЭРХ РУНИ БИЧЭЭС

Ц. Баттулга¹, У. Эрдэнэбат^{2,*}

Товч агуулга: Монгол-Германы Орхон Экспедиц 2019 онд Архангай аймгийн Хотонт сумын нутаг Уйгурын Хар балгасанд явуулсан хайгуулын явцад дээрээ эртний түрэг хэлээр руни бичгээр бичсэн бичээс бүхий хүрэл ялтас илрүүлэн олжээ. Бичээс нь хоёр мөр, нийт 9 үсгээс бүрдэх бөгөөд “Хятан эр [цэрэг]-ийн бүс” гэсэн утгатай байна. Энэхүү түүвэр олдвор нь эртний Уйгурын түүх соёлын судалгааны нэгэн сонирхолтой шинэ баримт юм.

Түлхүүр үг: Орхоны хөндий, Уйгурын хаант улс, Ордубалык, Хар балгас, руни бичээс

Удиртгал

Монгол-Германы Орхон Экспедиц (MONDOREX) Уйгурын эртний нийслэл Хар балгасыг малтан шинжлэх археологийн судалгааны хүрээнд хотын дүүрэг хорооллуудын бүтэц зохион байгуулалт, ашиглаж байсан он цаг, үүрэг зориулалт зэргийг нарийвчлан тодруулах зорилгоор системтэй хайгуул хийж сонирхолтой эх хэрэглэгдэхүүн цуглуулсаар байна. Тус төслийн 2019 оны хээрийн шинжилгээний хайгуулын явцад HB-5 талбайгаас бүсний чимэглэл бололтой жижиг хүрэл ялтас түүвэр байдлаар олдсон юм. Энэхүү эдлэлийн хээрийн шинжилгээний ангийн бүртгэлийн дугаар MONDOREX HB5/2019, Fund.Nr.: VM/06/09/S/009. Хүрэл, цутгамал, гонзгой дөрвөлжин, ерөнхий хэлбэр нь эрвээхэй мэт угалзарсан дүрстэй. Хэмжээ 2,9 см урт, 1,7 см өргөн, 0,1 см нимгэн. Дөрвөн буландаа тус бүр нэг цоолсон нүхтэй. Нүхний голч 0,15 см. Үүгээр товрууг бүсэн дээр хадаж тогтоож байсан бололтой.

Хүрэл ялтасны хоёр тал ямар нэгэн хээ чимэглэлгүй боловч сайн харвал нэг талд нь хоёр мөр руни бичээсийг хурц үзүүртэй багажаар зурчин бичсэн бичээстэй байна. Нэгдүгээр мөр таван үсэг, хоёрдугаар мөр дөрвөн үсэг тэмдэгтээс бүтсэн. Бичээсийг хэр баргийн хүн энгийн нүдээр олж харахааргүй боловч микро дуран, галт шилээр томруулж үзвэл маш тодорхой сайн харагдана.

Монгол Улсын нутгаас илэрсэн руни бичгийн дурсгалыг 1) гэрэлт хөшөө, хад чулууны бичээс, 2) ясан эдлэл дээрх бичээс, 3) модон эдлэл дээрх бичээс, 4) шавар вааран эдлэл дээрх, 5) металл эдлэл дээрх бичээс гэсэн таван төрөлд ангилсан байдаг (Баттулга 2022: 57). Хамгийн олон тоотой илэрсэн нь гэрэлт

хөшөө, хад чулууны бичээс бөгөөд одоогийн байдлаар ясан эдлэл дээрх 2 (чөдрийн чагт, нумын ясан наалт), модон эдлэл дээрх 1 (хөгжмийн зэмсэг), шавар вааран эдлэл дээрх 4 (Налайх орчмоос илрүүлсэн шавар хавтан, Туньюкукийн тахилын шаваас, Цэцүүхийн дээврийн ваар, Хиргисийн хоолойн дээврийн нөмрөг ваар), металл эдлэл дээрх 5 (хүрэл тамганы бичээс, “алтан хүн” дээрх бичээс, зоосон дээрх бичээс, мөнгөн савны бичээс, согд хийцийн мөнгөн аяга дээрх бичээс) бичээс илрээд байгаа ажээ.

Монгол-Германы хамтарсан шинжилгээний анги Уйгурын Хар балгасаас олж илрүүлсэн энэхүү олдвор манай улсын нутгаас олдсон төмөрлөг эдлэл дээрх руни бичгийн зургаа дахь дурсгал болж албан ёсоор бүртгэгдэж байна. Бичгийн боловсролтон, өндөр чадвартан уг бичээсийг бичсэн болох нь үсэг тэмдэгтийн зурлага, тиг хэлбэрээс илт анзаарагдана. Энэхүү хоёр мөр руни бичээсийг хүрэл тоногийг үйлдэх үед, магадгүй уг ялтсыг цутгасан урлаач, дархан бичсэн байх магадлалтай санагдана. Учир нь энгийнээр ажиглахад, он цагийн хувьд бичээсийг хожуу биш, харин эдлэлийг хийх үед бичсэн нэг цагийн үеийн цогц урлал хэмээн үзэж болохоор байна. Цаашид шаардлагатай тохиолдолд лабораторийн шинжилгээгээр нарийвчлан тогтоох боломжтой юм.

Хүрэл ялтсан дээрх бичээсийн эхийг сийрүүлбэл:

ᠬᠢᠲᠠᠨ ᠡᠷ
ᠪᠦᠰ

Үсгийн галиг:

1. QWRir
2. QiTny

Үгийн галиг:

1. qurī āg
2. qīṭany

Үгчилсэн орчуулга:

1. бүс нь эр (цэрэг)
2. хятан

¹ МУИС, Шинжлэх Ухааны Сургууль, Ази судлалын тэнхим

² МУИС, Шинжлэх Ухааны Сургууль, Антропологи, Археологийн тэнхим

* Холбоо барих зохиогч: u.erdenebat@num.edu.mn

<https://orcid.org/0000-0003-0867-3691>



Зураг 1. Хар балгасаас илэрсэн хүрэл ялтас

Гурван үгээс бүтэж буй уг бичээсийг монгол хэлнээ “Бүс Хятан эрийнх (цэргийнх)” буюу “Хятан эр [цэрэг] -ийн бүс” хэмээн утгачлан орчуулж болох юм.

Хүрэл эдлэлийн зүүн дээр булангаас баруунш ᠠᠷᠢᠭᠢ qurī är гэж хурц үзүүртэй багаж зэвсгээр харьцангуй жижгээр, түүний доор ᠶ᠋ᠠᠯᠢᠨ qītanu -Хятан гэдэг үгийг хоёрдугаар мөртэй тэнцүүлж, талбайг дүүргэн томоор бичжээ. Хоёрдугаар мөрийн ᠶ᠋ᠠᠯᠢᠨ гэдэг үгийг томоор бичсэн шалтгааныг дараах гурван байдлаар тайлбарлаж болох юм. Үүнд; нэгдүгээрт, мөрийг бичиж дуусахад хоёрдугаар мөрийн ганц үг бичих хангалттай зай талбай байснаас томоор бичсэн; хоёрдугаарт, эхлээд томоор ᠶ᠋ᠠᠯᠢᠨ qītanu гэж бичсэн боловч утга бүрэн илэрхийлэхгүй байсанд түүний дээд талд ᠠᠷᠢᠭᠢ qurī är гэж нэмж бичсэн; гуравдугаарт, өөрийн овог аймгийн нэрийг хүндэтгэн бахархалтайгаар ᠶ᠋ᠠᠯᠢᠨ qītanu гэж томоор бичсэн байх магадлалтай юм. Ямартай ч бүсний хүрэл чимэг тоног хийсэн, эсвээс хийлгүүлсэн тэр хүн өөрийн овог аймгийн нэр алдрыг ихэд эрхэмлэдэг, хятан хүн гэдгээрээ бахархдаг нэгэн байсан бололтой.

Хүрэл ялтсан дээр бичсэн үгсийн тухайд

ᠠᠷᠢᠭᠢ qurī -бүс нь. ᠠᠷᠢᠭᠢ qur -бүс, ᠢ ī хамаатуулах нөхцөл. Энэ үг руни бичгийн дурсгалд анх удаа тохиолдож байна. Э.Севортыны түрэг хэлний гарал зүйн толь бичигт бичигт kur kušak ‘пояс с украшением’- чимэглэл бүхий бүс гэсэн утгатайг тэмдэглэсэн (Севортыан 1997: 150) байх бөгөөд казах, каракалпак болон киргиз, алтай, хакас хэл

аялгуунуудад *кур бүс, эсгий гэрийн бүс, уйгур хэл аялгуунд үдээс (гутлын уяа) гэсэн утгаар хадгалагдан үлджээ. Уг үг түүхэн хөгжлийн явцад * qur < qurša , qurša - quša - qušak болж хувирсан байх бөгөөд орчин цагийн ихэнх түрэг аялгуунд бүсийг qušak бүс гэсэн утгаар түгээмэл хэрэглэгдэж байна.

ᠠᠷ är - эр, цэрэг. Нийт руни бичгийн дурсгалд хамгийн олон давтамжтай тохиолдох ба мөн ᠠᠷᠢᠭᠢ ärän -эрчүүд, цэргүүд, дайчид гэсэн олон тооны утгаар ч цөөнгүй тэмдэглэгдсэн байдаг билээ. “Монголын Нууц Товчоо” зэрэг эрт, дундад үеийн монгол хэлний бичгийн сурвалжид aran - ард, ардууд гэсэн утгаар түгээмэл тэмдэглэгдсэн байдаг. Алтайн хэлний дундын шинжтэй энэ үгийг түрэг, монгол төрөл хэлтнүүд одоо ч идэвхтэй хэрэглэсээр байна.

ᠶ᠋ᠠᠯᠢᠨ qītanu -Хятан. Хятан нь Түрэгийн хожуу хаант улсын түүхэнд төдийгүй Тан хийгээд Түрэгийн харилцаанд ч чухал үүрэг гүйцэтгэж байсан эртний монгол аймгуудын нэг юм. Хятан нар цаг үеийн нөхцөл байдлаас хамаарч зарим үед Түрэгүүдтэй хүч хавсран Тан улсыг довтолж, зарим үед гурван Курыкан, гучин Татаар, Татаби зэрэг монгол овог аймгуудтайгаа нэгдэж, эсвэл Тан улстай эвсэж Түрэгүүдийг довтолж байснаас үзэхэд, Түрэгийн хоёрдугаар хаант улсын албат харьяат биш, харин тэдний түшмэг улсын шинжтэй, бие даан оршиж байсныг харуулна. Тиймээс ч Түрэгийн хожуу хаант улсын цэргийн жанжин Күл тигин, Билгэ хаан, зөвлөх сайд Туныюкук нарын гэрэлт хөшөөний бичээст Хятан нартай холбоотой мэдээ баримт маш олон удаа дурдагджээ.

Түрэгийн хаант улс мөхсөний дараа Хятан нар Уйгур улстай харилцаагаа улам өргөжүүлж улмаар

худ ургийн харилцаатай болсон талаар түүхэн сурвалжуудад тэмдэглэсэн байна. Газар нутгийн байршлын давуу тал, худ ургийн харилцаагаа ашиглаж Тан улсын бараа бүтээгдэхүүнийг Уйгурын нийслэлд тээвэрлэн ирэх, худалдаалах, суурьшиж арилжаа худалдаа эрхлэх, дархан урчууд нь зэр зэвсэг, ахуйн хэрэглээний сав суулга, адуу малын тоног, гоёл чимэглэлийн зэрэг эд эдлэл урлахад ч тодорхой хэмжээгээр оролцож байсан нь лавтай. Эцэст нь тэмдэглэхэд, бүсний хүрэл ялтас нь тухайн үеийн нийтлэг хэрэглээ бүхий жирийн хүмүүсийн хэрэглэж байсан хувцас заслын чимэглэл болно.

Abstract

RUNIC INSCRIPTIONS ON BRONZE PLATE FROM KARABALGASUN

by Tsend Battulga and Ulambayar Erdenebat

In 2019, the Mongolian-German Orkhon Expedition (MONDOReX) discovered a bronze plate with runic inscriptions written in the ancient turkish language in the Karabalgasun of the Uyghur Empire (744/745-840) in Khotont Sum, Arkhangai Province, Mongolia. The inscription consists of two lines and a total of 9 letters, meaning “Qitan man’s [soldier] belt”. This find sample is an interesting new document in the study of the ancient Uyghur history and culture.

Keywords: Orkhon Valley, Uyghur Empire, Ordu-Baliq, Karabalgasun, runic inscription

Ном зүй

Баттулга, Ц. (2022). Монголын руни бичгийн шинэ судалгаа, Боть I. Улаанбаатар.

Севортян, Э.С. (1997). Этимологический словарь тюркских языков. Том 6. Москва.

Древнетюркский словарь, Ленинград, 1969, стр. 446.

Kaşgarlı Mahmut, Divanü Lügati-türk (Dizini): Vol. Cilt IV (Besm Atalay, Trans.). Türk Dil Kurumu Yayınları: 524, Ankara, 1999, s.379.

